



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ БНЭУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ухнаагийн Хүрэлсүх БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд Ражнат Сингх-ийг хүлээн авч уулзав. Оюун санааны түнш, гуравдагч хөрш БНЭУ-тай харилцаа, хамтын ажиллагаа олон салбарт өргөжин хөгжиж байгааг Ерөнхийлөгч тэмдэглэж, үүнд БНЭУ-ын Ерөнхий сайд Нарендра Модигийн 2015 онд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал болон Батлан хамгаалахын сайдын энэ удаагийн айлчлал чухал түлхэц болж байгааг онцлов.

Мөн хоёр орны хооронд тогтоосон Стратегийн түншлэлийн харилцааг Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаанд хүргэх бүрэн боломж байгааг хэлэв. Ардчилал, эрх чөлөөг дээдэлдэг зэрэг ижил төстэй зүйл олон Монгол Улстай харилцаа, хамтын ажиллагааг улам өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллахаа БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд Ражнат Сингх илэрхийлэв.

Уулзалтын үеэр олон улс, бүс нутгийн харилцан сонирхсон асуудал болон газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт, батлан хамгаалах, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал, боловсрол, агаарын тээвэр, аялал жуулчлал зэрэг салбарын харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов.



БНЭУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД РАЖНАТ СИНГХИЙН АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛ ЭХЭЛЛЭЭ



Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын урилгаар БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд Ражнат Сингх манай улсад 9 дүгээр сарын 05-07-ны өдрүүдэд албан ёсны айлчлал хийж байна. Өнөөдөр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд Ражнат Сингх нарын хоёр талын уулзалт боллоо.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр уулзалтын эхэнд БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд Ражнат Сингхт цар тахлын нөхцөл байдал хэвээр байгаа энэ цаг үед миний урилгыг хүлээн авч, айлчлал хийж буй явдалд талархал

илэрхийлээд, 16 жилийн дараа Монгол Улсад хийж буй энэ удаагийн айлчлал нь хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаанд илүү их үр дүн авчирч, өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэдгийг цохон тэмдэглэв.

БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд Ражнат Сингх хэлэхдээ, намайг сайхан Монгол орондоо урьсан явдалд талархаж байгаагаа илэрхийлэв. Монгол, Энэтхэг улсын хооронд стратегийн түншлэл тогтоосноос хойш Энэтхэгийн батлан хамгаалах яамны зүгээс анхны айлчлал болж байна. Энэхүү айлчлалын

үр дүнд хоёр улсын батлан хамгаалах, аюулгүй байдлын хамтын ажиллагаа, зэвсэгт хүчнүүдийн харилцаа улам гүнзгийрч, хөгжинэ гэдэгт итгэлтэй байна. Монгол улс бол Энэтхэгийн гуравдагч чухал хөрш юм хэмээн онцолсон юм.

Талууд хоёр улсын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа цэргийн бүх түвшний харилцан айлчлал, Батлан хамгаалах яамд хоорондын зөвлөлдөх уулзалт хийх, цэргийн мэргэжилтэн сургах, мэргэжил дээшлүүлэх, энхийг сахиулах болон хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулах зэрэг

хэлбэрээр амжилттай хөгжиж буйг тэмдэглээд, улам бат бэх харилцааг бэхжүүлнэ гэдэгт санал нэгдэв.

Түүнчлэн энэхүү айлчлал нь Монгол, Энэтхэг улсын цэргийн салбарт хамтран ажиллах, бүс нутгийн хэмжээнд цэргийн итгэлцэл, харилцан ойлголцлыг бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой бөгөөд цаашид хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэн, өргөжүүлэн хөгжүүлэхэд хамтран ажиллахад бэлэн гэдгийг харилцан тэмдэглэв.



Цахим шууданд

**МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН СУРГАЛТЫН ТӨВТЭЙ
БОЛЛОО**



Монгол Улс болон БНЭУ-ын Засгийн газар хооронд 2015 онд байгуулсан санамж бичгийн хүрээнд Үндэсний Батлан хамгаалахын их сургуульд Мэдээллийн аюулгүй байдлын сургалтын төвийг байгуулах ажил анх эхэлж байсан. Өнөөдөр тус төвийн үйл ажиллагааг нээх ёслолын арга хэмжээ боллоо.

Энэхүү сургалтын төвийг байгуулснаар ҮБХИС-ийн сонсогчид болон төрийн цэргийн байгууллагуудын алба хаагчдыг энэ чиглэлд мэргэшүүлж, чадавжуулах боломж бүрдэх юм. Энэтхэг Улсын зүгээс тус төвийн гурван лаборатори, номын сан, лекцийн танхим байгуулах болон иж бүрэн тоног төхөөрөмжийг суурилуулах ажилд үнэтэй хувь нэмрийг оруулсан билээ.



**ЗАХИРАГЧИЙН НЭРЭМЖИТ
ШАЛГАЛТ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА**

Зэвсэгт хүчний 110 дугаар анги



Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу захирагчийн нэрэмжит төгсгөлийн шалгалтыг ЗХЖШ-ын даргын тушаал, БИЦУГ-ын даргын заавар, зөвлөмж, ангийн захирагчийн тушаалын дагуу 2022 оны 9 дүгээр сарын 5-7-ны өдрийг дуустал гурав хоногийн хугацаатай зохион байгуулж байна.

Энэхүү шалгалтын эхний өдөр ангийн нийт бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг шалгаж, жагсаалын үзлэг явуулсны дараа байнгын бие бүрэлдэхүүн, ХЦАХ-даас цэргийн хэргийн мэдлэгийн онолын шалгалт, ажилтан албан хаагчдаас хууль эрх зүйн шалгалт авав. Өнөөдөр биеийн тамирын шалгалт, биеийн жингийн судалгаа авч байгаа бол маргааш шалгалтын буудлагыг Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн Сургалтын төвд явуулна.



Ахмад Т.МӨНХ-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ
ХҮЧИН ДАХИН НЭГ
РЕЙНЖЕРТЭЙ БОЛЛОО**

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс 6 дахь рейнжер төрлөө. Анхны шаг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг 2002 онд татаж байсан бол 2022 оны 8 дугаар сард Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлалын харьяа дугаар ангийн ахлах ахлагч Хүрэлбаатарын Эрдэнэдаваа Монгол Улсын 6 дахь рейнжер болж чадав. Түүнтэй АНУ-ын Рейнжерийн сургуулийн сорилтуудын тухай, хэрхэн давж гарсан тухай ярилцсанаа хүргэе.

АНУ-ын Рейнжерийн сургуулийг амжилттай төгссөнд тань баяр хүргэе. Сургуульд хамрагдахын тулд өөрийгөө өмнө нь бэлтгэж байв уу?

-Баярлалаа. Тусгай хүчний цэргийн командлалаас "АНУ-ын Рейнжерийн сургуулийн хуваарь ирсэн. Та өөрийгөө тэнцэнэ гэж бодож байна уу, оролцох уу" гэсэн санал дэвшүүлэхэд нь дуртайяа зөвшөөрсөн. Хэлний бэлтгэлгүйгээр өнгөрсөн 4 дүгээр сард рейнжерийн өмнөх сургалтад хамрагдсан. Шаардлагатай гэж үзвэл хэлний бэлтгэлд хамрагдах боломжтой л доо. Харамсалтай нь рейнжерийн өмнөх сургалтад хамрагдаж байхдаа хөлийн хуруугаа гэмтээж, арга буюу завсарлага авч, эмчлүүлсэн. Хэрэв бага хэмжээний гэмтэлтэй бол завсарлага авч, эмчлүүлээд дараагийн сургуульд нь хамрагдах боломжтой гэсэн үг. Ингээд 6 дугаар сарын дунд үеэс 8 дугаар сарын 19-ний өдөр хүртэл 62 хоногийн хугацаатайгаар АНУ-ын Рейнжерийн сургуулиа амжилттай дүүргэж, төгссөн.

Мэдээж сургуулийн сорилтууд маш хүнд гэлцдэг, төгсөхөөсөө илүү унах нь олон гэдэг шүү дээ...

-Тэгэлгүй яах вэ. АНУ-ын цэргийн алба хаагчдаас гадна

гэдэг хамгийн хэцүү. Америк цэргүүдийн гэхэд 60 хувь нь төгсөж чаддаг юм билээ. Надад бол төгсөхөөс өөр зам байгаагүй.

Нэгдүгээрт, эх орон, Зэвсэгт хүчний удирдлагын өгсөн итгэл. Хоёрдугаарт, дараа дараагийн залгамж халааныхаа замыг нь хаачихгүй юм сан гэдэг хариуцлага. Хэрэв тухайн орноос ирсэн цэргийн алба хаагчид сорилтдоо унаад байвал дараа дараагийн элсэлт авахаа зогсоодог хатуу дүрэмтэй.

Сургуулийн сорилтуудын онцлогоос дурдахгүй юу?

-Гурван үе шаттайгаар явагддаг. Үүний өмнө шаардлагатайгжүзвэлхэлний бэлтгэлд, үргэлжлүүлээд рейнжерийн өмнөх сургалтад заавал хамрагдана. Нэгдүгээр үе шатад нам дор газарт тасгийн тактик, жижиг бүлгээр үүрэг гүйцэтгэнэ. Хоёрдугаар үе шатад хад хавцал уулархаг газар районд салааны түвшинд үүрэг гүйцэтгэнэ. Гуравдугаар үе шатад намаг, усанд байлдааны ажиллагааг удирдан явуулах салааны түвшинд үүрэг гүйцэтгэнэ. Энэ хугацаанд алдаа гаргавал хасагдана. Ялангуяа, сум алдах, аюулгүй ажиллагааны дүрмийг ноцтой зөрчих, сахилга, хариуцлагын алдаа



санагдсан даалгавар нь юу вэ?

-АНУ-ын Жон Кеннедигийн нэрэмжит Тусгай хүчний сургуулийн Ахлагчийн дамжааг 2018-2019 онд төгссөн маань их туршлага боллоо. Юу гэхээр энэ дамжаагаар АНУ-ын цэргийн тактик, жижиг бүлгийн талаар суралцсан учраас дөхөмтэй байсан гэж хэлж болно. Мэдээж сорилт бүр хүнд бөгөөд хамгийн амаргүй нь гэвэл уулархаг газар районд үүрэг гүйцэтгэх бас нойр, хоолгүй явах нь байлаа. Нөгөө талдаа сургуульд хамрагдаж байгаа цэргийн алба хаагчдын дундаж нас 22-24 байдаг юм

биелсэнд маш их баяртай байна. Намайг дэмжиж явуулсан Зэвсэгт хүчний Жанжин штаб, Тусгай хүчний цэргийн командлал, ангийн удирдлагадаа талархаж байна. 2021 онд АНУ-ын Рейнжерийн сургуулийг амжилттай дүүргэж, надад харамгүй зөвлөгөө өгсөн онжав болох сургагч ахлагч А.Мөнгөншагай, ахмад Г.Жавхлантөгс хоёртоо ч баярлаж байна.

Төгсгөлийн баяр дээр "Монгол цэрэг Хүрэлбаатар" гээд эх орноороо, бас аавынхаа алдраар дуудуулж зогссон нь юутай ч зүйрлэшгүй бахархам агшин байлаа. Монгол Улсын Зэвсэгт хүчний 6 дахь рейнжер бөгөөд хоёр дахь рейнжер ахлах ахлагч болж чадсандаа баяртай байна.

Зэвсэгт хүчнийхээ эгнээнд хэзээ элсэж байсан бэ?

-2009-2010 онд ҮБХИС-ийн Ахлагчийн сургуулийг төгсөж, ажлын гараагаа Зэвсэгт хүчний 330 дугаар ангиас эхлүүлсэн. Энэ хугацаанд 2018-2019 онд АНУ-ын Жон Кеннедигийн нэрэмжит Тусгай хүчний сургуулийн Ахлагчийн дамжаа, АНУ-ын Шүхэр десантын дамжаа, 2021 онд АНУ-ын Шүхрийн хэт өндрийн чөлөөт уналтын дамжааг тус тус төгссөн. Зэвсэгт хүчинд 13 дахь жилдээ үүрэг гүйцэтгэж байна.

Таны залгамжийг авах залуус хэр олон байна гэж хэлэх вэ?

-Олон гэдэгт итгэдэг. Монгол цэргийн гайхамшигт түүх энх цагт ч гүйцэтгэж буй үүрэг, тэсвэр хатуужил, эр зоригороо давтагдаж байх ёстой. Бэлтгэгдсэн цэргээс илүү хүчтэй зэвсэг гэж байхгүй гэдэг шүү дээ. Түүн шиг залуу офицер, ахлагч нар өөрийгөө шат дараатай бэлтгэж, ажил албандаа ур чадвар, хүсэл тэмүүлэл, зорилго чиглэл, идэвх оролцоогоороо манлайлах ёстой.

Ахлах дэслэгч Д.БОЛОР



гаргавал хасагдана.

Бүлэг, тасгаар үүрэг гүйцэтгэж байгаа учраас багийн ажиллагаа хамгийн чухал. Тэр багийн амжилтыг хойш татаж, алдаа гаргахгүйн төлөө цэргийн алба хаагчид хүн нэг бүрийн үүргээ мадаггүй биелүүлэх гэж маш их уйгагүй хичээнэ. Өдөрт дунджаар хоёр цаг л унтдаг гээд бодохгүй юу.

Танд хамгийн хэцүү

байна. Миний хувьд 30 нас дөнгөж гараад энэ сургуульд хамрагдсан болохоор хөгшин оюутандаа орж байсан шүү.

Зүүн мөрөн дээрээ рэйнжер тэмдгээ зүүлгэж байхдаа юу бодогдож байв?

-Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагчид дэлхийн аль ч орны цэргийнхнээс дутахгүй гэдгийг л харуулахыг зорьсон. Зорилго минь